



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/449

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."б" заалт, Засгийн газрын 2018 оны "Атрын 60 жил бүтээлч ажил өрнүүлэх тухай" 76 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.2.4.19, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны "Ой тэмдэглэх тухай" 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн түүхэн баримтат кино бүтээхэд 5.000.000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 5.000.000 (таван сая) төгрөгийг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100784